

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны .. дугаар
сарын ..-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Усны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.10, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол орны усны сав газрыг 1 дүгээр, түүнд хамрагдах талбайн хэмжээг шинэчлэн 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж, сав газрын захиргаадыг удирдлага, арга зүйгээр ханган ажиллахыг Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мягмар, Сав газрын удирдлагын хэлтсийн дарга Н.Баттулга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Монгол орны Усны сав газрыг батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 332 дугаар тушаалын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
 2017 оны ... сарын ...-ны өдрийн
 ... дугаар тушаалын .. дүгээр хавсралт



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2017 оны ... сарын ... -ны өдрийн
... дугаар тушаалын ... дугаар хавсралт

**Монгол орны усны сав газруудад хамрагдах талбайн хэмжээ,
томоохон цутгал голуудын нэрс**

№	Сав газрын нэр	Сав газрын талбай, км ²	Сав газар дахь томоохон цутгал голууд, булаг, сайр
1.	Сэлэнгэ	31368,83	Асгат, Шивэрт, Харганат, Бух, Галттай, Зоох, Оргих
2.	Хөвсгөл нуур-Эг	41835,64	Үүр, Цагаан бургас, Бургалтай, Эрин, Тарвагатай
3.	Шишхэд	20345,46	Арсайн, Саргай, Тэнгис, Хар баранга, Жагаш
4.	Дэлгэрмөрөн	23304,46	Агар, Бэлтэс, Шарга, Бах, Бүгсэй
5.	Идэр	23042,16	Жаргалант, Ямаат, Өвөр хожуул, Зарт, Хөнжил, Бүгдэгээ
6.	Чулуут	20060,93	Суман, Их жаргалант, Их Улиастай
7.	Хануй	15741,71	Донгой, Цохиот, Бугат, Зуслан, Могойт, Балиг
8.	Орхон	53410,18	Хойд Тамир, Асгат, Угалз, Хангал, Шар ус, Бургалтай
9.	Туул	50032,58	Хаг, Галттай, Арцат, Баруун баян, Тэрэлж, Налайх, Гачуурт, Хөл, Улиастай, Сэлбэ, Түргэн, Бүхэг, Хар бух
10.	Хараа	17681,92	Баян, Сөгнөгөр, Хужирт, Өлгий, Балж, Дарст, Бороо, Загдал, Наран
11.	Ерөө	22261,01	Шарлан, Захар, Шар
12.	Онон	28217,71	Эг, Барх, Хурх, Шууст, Балж
13.	Улз	37929,78	Туулайт, Урт, Дөч
14.	Хэрлэн	107815,87	Хүүш, Хужирт, Цэнхэр, Мөрөн
15.	Буйр нуур-Халх	23735,92	Гуут, Нөмрөг, Нарийн, Халиут
16.	Мэнэнгийн тал	54036,78	Хонгор, Гэээгт
17.	Умард говийн гүвээт-Халхын дундад тал	180404,22	Элэгний булаг, Нүдэнгийн булаг
18.	Галба-Өөш-Долоодын говь	142167,84	Лүг /түр урсацтай/
19.	Онги	39691,2	Хэрэмт, Задгай
20.	Алтайн өвөр говь	212588,84	Хужирт, Сагсай, Цагаан /түр урсацтай/
21.	Таац	25403,96	Аргуй, Могой
22.	Орог нуур-Түй	15722,22	Хужирт, Нарийн
23.	Бөөнцагаан нуур-Байдраг	35592,18	Заг, Өлзийт, Шорвог
24.	Хяргас нуур-Завхан	122212,86	Шурга, Хүнгүй
25.	Хүйсийн говь-Цэцэг нуур	42988,45	Хөшөөт, Зүйл, Дунд шарга, Халиун
26.	Үенч-Бодонч	34462,53	Хараат, Цагдуул, Ангирт
27.	Булган	10146,27	Ёлт, Түргэн, Улиастай
28.	Хар нуур-Ховд	88860,77	Өмнө, Шар, Улиастай, Буянт
29.	Увс нуур-Тэс	54177,29	Жарантай, Шавартай, Түргэн, Боршоо, Тээл, Хөндлөн, Хархираа
Нийт талбайн хэмжээ		1 575 239,57	

